

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН  
АШИГ СОНИРХОЛ БОЛОН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН  
АЛБАН ҮҮРЭГ  
ХООРОНДЫН ЗӨРЧЛӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

*Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс  
урьдчилан сэргийлэх тухай хууль болон авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд*

Хуульч М. Үүрийнтуяа

**Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг:** *(Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл)*

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх
- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;



АВЛИГА БА АШИГ  
СОНИРХОЛ



АВЛИГА ГЭЖ ЮУ ВЭ?

Ашиг сонирхол гэх ойлголттой  
ХЭРХЭН УЯЛДДАГ ВЭ?

# АВЛИГА УУ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮ?

- **Авлига** гэдгийг “итгэж олгосон эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход ашиглах” гэж тодорхойлдог.
- **Хувийн ашиг хонжоо** гэдэгт өөрийн санхүүгийн болон нийгмийн сонирхол, гэр бүлийн гишүүд, дэмждэг улс төрийн нам, харьяалагддаг эвсэл, холбоодод ашиг хонжоо бий болгохыг ойлгоно.

Эндээс үзэхэд авлига болон ашиг сонирхлын зөрчил нь нэг зүйлийн хоёр тал юм.

- Авлигыг “итгэж олгосон эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход ашиглах” хэмээн тодорхойлдог. Энгийн үгээр хэлэхэд, авлига нь эрх мэдлээ хувийн эрх ашигт урвуулан ашиглахыг хэлдэг байна.
- Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь бичиг”-т “Авлига гэдэг нь ёсон бусаар шунаж авсан эд юм” гэжээ. Авлига нь хээл хахууль, шан харамжийн шинжтэй үйлдлүүдийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд маш олон хэлбэрээр илэрдэг байна.

- Тиймээс ашиг сонирхлын зөрчил нь нэг талаас нийтийн албан тушаалтны ёс зүйн шаардлага, нөгөө талаас авлигын сүүдэр шалтгаан болдог.
- Нийтийн албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэхэд хувийн ашиг сонирхол нь зүй бусаар нөлөөлсөн үед авлига бий болдог нийтлэг зүй тогтол байдаг.

- Ашиг сонирхлын зөрчил нь авлига биш харин авлига бий болох үндэс суурь, шалтгаан болдог. Товчоор хэлбэл, авлига бол ашиг сонирхлын зөрчлийн төгсгөлийн шат юм. Иймд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үр дүнтэй арга хэмжээ болно.



- Авлига нь гэмт хэрэг, зөрчил байдаг бол ашиг сонирхлын зөрчил нь авлигатай харьцуулахад албан тушаалаа зүй бусаар ашиглан хувьдаа санхүүгийн ашиг олохгүй ч албан үүргээ гүйцэтгэхдээ танил тал харсан, алагчилсан байдлаар гүйцэтгэхэд хүргэдэг.
- Энэ нь ихэвчлэн эрүүгийн гэмт хэрэг болж хуульчлагдаагүй боловч нийтийн албаны ёс зүйн болон захиргааны зөрчилд тооцогдох олон төрлийн зан үйлийн хэлбэрүүдийг өөртөө багтаадаг.

# ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- Авлигын эсрэг хууль болон Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээд:

“төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан”

## ТА ҮҮНИЙГ БАРИМТАЛЖ АЖИЛЛАДАГ УУ?

- Төрийн сонирхолд үйлчлэх
- Тунгалаг байдал: Гаргасан аливаа шийдвэрийнхээ үндэслэлийг эрх бүхий байгууллагад тайлагнах болон хариуцлага хүлээх үүрэгтэй
- Шударга ёс: Өөрийн хувийн сонирхлыг харгалзахгүй байх үүрэгтэй
- Үр ашигтай байх: Нийтийн албан тушаалтан нь төсвийн хөрөнгийг зарцуулах болон төрийн өмч, хөрөнгийг ашиглахдаа дээд зэргийн үр ашигтай байх, нөөцийг үрэн таран хийх, хэт үнэтэй зүйлсэд зарцуулахаас зайлсхийх үүрэгтэй.

# АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ТОГТООЖ, МӨРДҮҮЛЭХ

- Төвийн хэмжээнд мөрдөгдөж буй ёс зүйн дүрмийг олж авах, уншиж судлах, үйл ажиллагаандаа нэг мөр баримтлах - Ойлгохгүй зүйл байвал хамт олонтойгоо ярилцах, эрх бүхий албан тушаалтнаас зөвлөгөө, тусламж авах.

# АВЛИГЫН НӨХЦӨЛ ШАЛТГААН



- “Corruptio” гэсэн латин үгнээс гаралтай “corruption” хэмээх англи үг нь шударга бус, хээл хахууль авдаг, ёс суртахуунгүй, зан чанар нь эвдэрсэн, ялзарч доройтсон байдлыг илэрхийлдэг. Латин үгийн гарал нь гадны нөлөөгөөр химийн болон электрохимийн урвалд орсны улмаас металл үндсэн шинж чанараа алдахыг нэрлэсэн утгатай юм.

- “Авлига” гэж:

Эрх бүхий этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

- “Ашиг хонжоо” гэж:

Эрх бүхий этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

- “Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж:

Эрх бүхий этгээд эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдлийг хийхийг;

“Давуу байдал” гэж:

Эрх бүхий этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлнэ.





ТА ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд дараах арга хэмжээг авна:

- ✓ Саналаас татгалзах;
- ✓ Санал тавьсан этгээдийг тодорхойлох;
- ✓ Тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг хадгалах ба энэ тухай өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх;
- ✓ Боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх;
- ✓ Болсон нөхцөл байдлын талаарх мэдэгдлээ боломжит хугацааны дотор өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлэх;
- ✓ Хариуцлага хүлээхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА !